ШИВЭЭ ОВОО

# "ШИВЭЭ-ОВОО"
# ХУВЬЦААТ КОМПАНИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 13 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Шивээ Овоо ХК-ийн дүрмийн 3.2 3.2.1-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 10 цагт Нийслэл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, 9 дүгээр байр, "А1" тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Наранцогт/-ыг томилсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах болон тооллогын комиссыг 1 дүгээр хавсралт ёсоор, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, зохион байгуулалтын удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралт ёсоор, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг 4 дүгээр хавсралт ёсоор, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар "Санал авах хуудас"-ны загварыг 5 дугаар хавсралт ёсоор, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох "санал авах хуудас"-ны загварыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-д даалгасугай.

ДАРГА Д.НЯМДЭЛГЭР